



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/558

Улаанбаатар хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай” А/480 дугаар захирамжийн 2 дугаар хэсгийн “... дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 50 км-ээс хэтрүүлэхгүй байхаар ...” гэснийг “... дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 40 км-ээс хэтрүүлэхгүй байхаар ...” гэж өөрчилсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаад даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ